



**МОНГОЛ УЛСЫН
НООС НООЛУУРЫН САЛБАРЫН СУДАЛГАА**

Удиртгал

Ноос ноолуурын салбар нь Монгол Улсын эдийн засгийн бүтэц дэх уламжлалт бөгөөд стратегийн ач холбогдолтой үйлдвэрлэлийн нэг бөгөөд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын голлох суурь болж ирсэн билээ. Монгол Улс жил бүр ойролцоогоор 10 мянган тонн орчим түүхий ноолуур, 20 мянга гаруй тонн ноос бэлтгэдэг бөгөөд дэлхийн ноолуурын нийлүүлэлтийн 40–48 хувийг дангаар бүрдүүлдэг нь энэ салбарын олон улсын өрсөлдөх чадварыг илтгэн харуулдаг. Ноолуур, ноосон бүтээгдэхүүний экспорт нь уул уурхайн бус экспортын дотор тогтмол дээгүүр байр эзэлж, хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүний бүтцэд чухал байр суурийг эзэлдэг.

Гэсэн хэдий ч ноос ноолуурын салбарын хөгжлийн түвшин өнөөг хүртэл түүхий эдийн шатанд төвлөрсөн хэвээр байсаар байгаа нь үйлдвэрлэлийн үр ашиг, экспортын орлогыг хязгаарлах гол хүчин зүйлсийн нэг болж байна. Тухайлбал, түүхий буюу самнасан ноолуурын экспорт давамгайлж, гүн боловсруулалт буюу утас, даавуу, ноолууран хувцас, бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл харьцангуй бага хэвээр байна. Үүний улмаас нэмүү өртгийн ихээхэн хэсэг нь гадаадын зах зээл дээр шингэж, дотоодын аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар бүрэн ашиглагдахгүй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар болон хувийн хэвшил нягт хамтран ажиллаж, “Цагаан алт” хөтөлбөр, экспортын бодлогын шинэчлэл, боловсруулах үйлдвэрлэлийн дэмжлэг зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлснээр ноос ноолуурын салбарын зохицуулалт, хөгжилд тодорхой ахиц гарч байна. Хялгас ялгалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, ээрэх, нэхэх, сүлжих үйлдвэрлэлийн шугамуудыг шинэчлэх, чанарын стандартын хяналтыг сайжруулах, экспортын бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлэх зэрэг алхмуудыг хийж буй нь салбарын ирээдүйн боломжийг улам өргөжүүлж байна.

Иймд энэхүү судалгааны ажлын зорилго нь Монголын ноос ноолуурын салбарын өнөөгийн төлөв, худалдаанд эзлэж байгаа байр, суурьт, зах зээлийн нөөц боломж болон салбарт хөрөнгө оруулах боломжийг тодорхойлох, салбарын цаашдын хөгжлийн боломж, чиглэлийг тодорхойлох явдал юм.

Энэхүү судалгаа нь түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ, боловсруулах үйлдвэрлэлийн бүтэц, экспортын динамик, зах зээлийн эрэлт, технологийн шинэчлэл, бодлогын орчин зэрэг олон талын хүчин зүйлсийг хамарсан.

САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Ноос, ноолуурын салбартай холбоотой стратегийн баримт бичгүүд

Монгол Улсын хуулиуд:

- Хөдөө аж ахуйн тухай хууль
- Мал хамгаалах тухай хууль
- Хүнсний аюулгүй байдлын тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хууль
- Татварын ерөнхий хууль / татварын хөнгөлөлтийн зохицуулалт
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Экспортын бодлогын тухай ЗГ-ын шийдвэрүүд

Монгол Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичиг:

- Алсын хараа 2050
Ноос, ноолуур, арьс ширийг экспортын голлох салбар гэж тодорхойлж Боловсруулалтын түвшинг ахиулах “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн нэмүү өртгийн сүлжээг өргөжүүлэх зорилтыг тусгасан.
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2016–2025)
Монгол Улсын хүнсний баталгаат байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой, өрсөлдөх чадвартай, шинжлэх ухаанд суурилсан систем болгон хөгжүүлэх. Үүнд:
Үндэсний аюулгүй байдлын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын суурь тогтвортой байдлыг хангах, дотоодын хэрэгцээг бүрэн хангах, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон үйлдвэрлэл хөгжүүлэх
- Шинэ сэргэлтийн бодлого 2022–2030
Ноос, ноолуур, арьс ширийг экспортын голлох салбар гэж тодорхойлж боловсруулалтын түвшинг ахиулах, “Цагаан алт”-ын нэмүү өртгийн сүлжээг өргөжүүлэх зорилт туссан
- Монгол Улсын ноолуурын салбарыг 2030 он хүртэл тогтвортой хөгжүүлэх замын зураглал

Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- “Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 19 дүгээр тогтоол (2022.05.05)
УИХ-аас салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг Засгийн газарт даалгасан:
 - Ноолуурын боловсруулалтын түвшнийг үе шаттай нэмэгдүүлэх
 - Хялгас ялгах түүнээс дээш боловсруулсан ноолуурын экспортын зохицуулалт
 - Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх хуулийн төсөл боловсруулах

- Малчин, мал бүхий этгээдэд түүхий эдийн чанараас хамаарсан урамшуулал олгох эрх зүйн орчин бүрдүүлэх
- Бүтээгдэхүүний чанар, стандартын лаборатори хөгжүүлэх

- “Цагаан алт” хөдөлгөөн УИХ-ын 63 дугаар тогтоол (2024)
 - Ноолуурын гүн боловсруулалтын түвшинг 2028 он хүртэл 40% хүргэх
 - Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дэмжих
 - Экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
 - Түүхий ноолуурын экспортыг бууруулах
 - Дотоодын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл
 - Тогтвортой мал маллагааны бодлого

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай” ЗГ-ын 380 дугаар тогтоол (2022.10.19)
- “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 101 дүгээр тогтоол (2020.03.19)
- “Монголын хаан ширхэгт бүтээгдэхүүний чанарын стандарт” ЗГ-ын 291 дүгээр тушаал (журмын түвшний шийдвэр)

МОНГОЛ УЛСЫН НООС НООЛУУРЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Монголын мал аж ахуй нь байгалийн бэлчээрт суурилсан уламжлалт нүүдлийн тогтолцоотой, үндэсний хүнс, түүхий эдийн гол эх үүсвэр бөгөөд эдийн засгийн стратегийн салбарын нэг юм.

Үндэсний статистикийн хорооны гаргасан мэдээллээр(2024) Монгол улс 57,6 сая малтай, үүнээс хонь 24,5 сая, ямаа 22,9 сая, үхэр 5,1 сая, адуу 4,7 сая, 480,6 мянган тэмээ тоологджээ¹. Малын тоо өмнөх оныхоос 7.0 сая (10.9%)-аар буурсан байна. **Малын төрлөөр авч үзэхэд, хонь 4.9 сая (16.7%), ямаа 1.7 сая (6.9%), үхэр 276.4 мянга (5.2%), адуу 146.6 мянга (3.0%)-аар тус тус буурч, тэмээ 6.7 мянга (1.4%)-аар өссөн байна.**

Манай улсын хөдөлмөр эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь буюу 308.7 мянган малчид мал аж ахуйн салбарт ажиллаж байна². **Малчдын тоо (2024) өмнөх оноос 10.4 мянга буюу 3.5 хувиар өссөн байна.** Нийт малчдын 185.4 мянга буюу 60.1 хувь нь эрэгтэй, 123.3 мянга буюу 39.9 хувь нь эмэгтэй малчид байна. Малчдын тоог аймгаар, өмнөх оныхтой харьцуулан авч үзэхэд, Говьсүмбэр Баянхонгор, Дорноговь, Өмнөговь аймагт 5 - 338 -аар буурсан бол бусад аймгуудад 27 - 1233 -аар өссөн байна.

Нөөц, түүхий эд, боловсруулалт, үйлдвэрлэл

1. Түүхий эд бэлтгэл, биологийн нөөц боломж (Малын тоо толгой)

Хүснэгт 1. 2024 оны мал тооллогын дүнгээр түүхий эдийн нөөц боломж³:

	2024 онд	Жилд дунджаар	Тайлбар
Ямаа (22.9 сая)	8,500-9,000 /2023-2024 оны өвлийн хорогдлоос үүдэлтэйгээр хэмжээ буурсан/	9,500-10,000 тонн	Нэг ямаанаас дунджаар 250-350 грамм ноолуур гардаг.
Хонь (24.5 сая)	34,200 мян.тн	30,000-35,000 тонн хонины ноос бэлтгэх нөөцтэй	10 орчим хувь нь нарийн ноос байдаг.
Тэмээ (480.6 мянга)	1900 мян.тн	Жилд 2,000 тонн орчим тэмээний ноос бэлтгэх боломжтой	
Сарлагийн хөөвөр	397,6 мян.тн	Жилд 400-500 тонн хөөвөр бэлтгэх нөөцтэй.	

¹ https://downloads.1212.mn/_UW5bC_wIMx6NGpwT41M-i0tvK0ODm_-hcjZLB-Z.pdf

² https://downloads.1212.mn/_UW5bC_wIMx6NGpwT41M-i0tvK0ODm_-hcjZLB-Z.pdf

³ Монгол Улс Үндэсний Экспортын Стратеги 2024-2028 /ноос, ноолуурын экспортын стратеги/, 28 дахь тал

Эх сурвалж: Монгол Улс үндэсний экспортын стратеги 2024-2028/ ноос, ноолуурын экспортын стратеги

2. **Чанарын нөөц боломж (Өнгө ба сорт)** Монгол ноолуур нь өнгөний төрөл зүйлээрээ (цагаан, цайвар, бор, хөх) дэлхийд гайхагддаг, будах шаардлагагүй "эко" бүтээгдэхүүн үйлдвэрлэх давуу тал болдог. Цагаан ноолуур: Нийт нөөцийн 20-25%-ийг эзэлдэг (Завхан, Баянхонгор аймагт). Сортлох боломж: Түүхий эдийг малчны хотноос үйлдвэр хүртэлх шатанд зөв ангилан ялгаж чадвал экспортын үнэлэмжийг 20-30%-иар өсгөх боломжтой.



Эх сурвалж: Шаравдэмбэрэлийн Энхтуул (2023) Монголын ноолуурын салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх нь: Кластер загварын хандлага (докторын диссертаци), МУИС

Зурагт ноос ноолуурын боловсруулалтын үе шатыг нэмүү өртөг нэмэгдэх тооцооллын хамт харуулсан бөгөөд салбарын онцлог нь түүхий эдэд боловсруулалт хийх тусам нэмүү өртөг шингээж байдаг чухал салбар юм.

3. **Боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадал:**

	Бүрэн чадамж	Одоогоор ашиглаж буй	Ашиглалтын хувь
Түүхий ноолуур	8,000-10,000 тонн		
Угаах	6,000-7,000 тонн	6,000-7,000 тонн	100%
Самнах	4,250 тонн	934 тонн	22%
Ээрмэл утас	4,330 тонн	440 тонн	10%
Эцсийн бүтээгдэхүүн	20 сая ширхэг	2 сая ширхэг	10%

Эх сурвалж: Монгол Улс үндэсний Экспортын Стратеги 2024-2028 /ноос, ноолуурын экспортын стратеги/

Хүний нөөц: Маллах, түүхий эдийг малчны хотхоноос цуглуулах анхан шатанд 248,294 малчин, боловсруулах, үйлдвэрлэх, жижиглэн худалдааны салбарт 10,000 орчим хүн, улсын хэмжээнд нийт хүн амын 9% нь ноос ноолуурын салбарт ажиллаж байна.

НООС, НООСОН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022
Угаасан ноос	тн	3340.1	3369.7	1786.5	3555.8	5355.8
Самнасан хонины ноос	тн	228.5	83.2		300.5	593.4
Самнасан ноолуур	тн	1160.3	774	516.4	512	919.5

Угаасан ноолуур	тн	1331.8	1288.5	1683.1	2831.1	3807.1
Ноолууран ээрмэл	тн	492.1	334.2	245.5	215.8	192.6
Ноосон нэхмэл	тн	606.6	527	250.2	47.4	30.2
Тэмээний ноосон хөнжил	мян.м	9.4	9.9	17.8	19.7	24
Хивс	мян.м2	528.2	478.3	361.4	379.3	423.7
Эсгий	мян.м	112.1	187.4	100.5	171.3	388.8

Эх сурвалж: ХХААХҮЯ-ын аж үйлдвэрийн салбарын танилцуулга (2025)

4. Үйлдвэрлэгчид:

Үйлдвэрүүдийн тоо, хүчин чадал	Улаанбаатар	Орон нутаг	Хүчин чадал /тонноор/	Ашиглалт
Хялгас ялгах	45	5	11,964	8530
Угаах үйлдвэр	34		13,000	77%
Ээрэх үйлдвэр	16		2278	31.40%
Сүлжих, нэхэх цогцолбор ЖДҮ	14			
	80			

Боловсруулалтын түвшин	
Анхан шатны боловсруулах үйлдвэр	23
Гүн боловсруулах үйлдвэр	15
Сүлжмэлийн ЖДҮ	80
Өрхийн жижиг цех	150-200

Гүн боловсруулах үйлдвэрүүд нь ноос ноолуур боловсруулах цогцолбортой байгаа бөгөөд үйлдвэрлэлийн 60 орчим хувийг бүрдүүлж байна. Дурьдвал: Говь ХК, Гоёо ХХК, Гоёл кашемир ХХК, Ханбогд кашмир ХХК, Ээрмэл ХК, Улаанбаатар хивс ХК зэргийг нэрлэж болно.

Нийт түүхий эдийн 10 хувь нь ноос ноолууран хувцас эдлэл болсон байгаа нь үйлдвэрлэлийн явцад нэмүү өртөг шингээх шаардлага байгааг харуулж байна. Энэ салбарын нэмүү өртгийг нэмэгдүүлэх үүднээс бодлогын болон хэрэгжилтийн дараах бичиг баримтуудыг батлан гаргажээ.

Дотоод, гадаад зах зээлийн боломж

Монгол Улс 2025 онд нийт **15,701,472.6** сая.долларын экспорт, **11,312,088.4** сая долларын импорт хийж гадаад худалдааны тэнцэл 4,4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Уул уурхайн бус экспорт 778,8 сая ам.доллар, нийт экспортод эзлэх хувь нь 5,3 % байна. Үүнээс 356,100.79 сая ам.долларын түүхий эд, ээрмэл экспортлосон нь нийт экспортын 2.3% байна. Монгол Улс дэлхийн ноос, ноолуурын түүхий эдийн зах зээлийн 40 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг.

Хүсгнэгт 2. Угаасан, самнасан ноос, ноолуурын худалдааны байдал

/мянган ам.доллараар/

51⁴. Хонины ноос, мал, амьтны нарийн эсвэл бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл болон нэхмэл даавуу.

Экспорт	325,629	455,343	400,266	363,582	358,453
Импорт	9,342	4,676	19,840	12,523	4,045

Эх сурвалж: ГЕГ статистик

Ноос ноолууран бүтээгдэхүүн буюу бэлэн хувцас эдлэлийн хувьд: 2025 нийт 30095.36 сая ам.долларын бүтээгдэхүүнийг экспортлосон бөгөөд нийт ноос ноолуурын экспортын 1,06 эзлэж байна. Угааж самнасан ноос, ноолуур салбарын экспортын 85-90%-ийг бүрдүүлдэг. 2025 онд экспортын 92 орчим хувийг эзэлсэн байна.

Худалдан авагч улсууд: гол импортлогч БНХАУ байна. 2025 онд нийт экспортын 80.13 хувь, Европын холбооны орнууд 18 хувийг, 1,87 хувийг бусад орнууд.

Хүснэгт 4. Ноос ноолууран ээрмэл, утас, даавууны экспорт, импортын дэлгэрэнгүй /горимын кодоор/

Барааны нэр/БТКУС код	Бүр/тоо	100	400	502	202	442	990	201	203	621	623	212
Самнасан ноолуур 5105	529	521	3		4		1					
Нэхмэлийн утас, ээрмэл 5106	23	8	12	2								
Ноосон утас 5107	26	3	20	1		2						
Ноолууран болон ноолуурын хольцтой утас 5108	366	115	97	87	5	60						
Ноолууран, нэхмэлийн утас 5109	31	23	8									
Ноос, ноолууран, нэхмэл даавуу 5111	196	23	14		40			54	9	49	3	4

Эх сурвалж: ГЕГ

Горимын кодын тайлбар:

100: Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэнд байгаа монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах /шууд экспорт/

400: Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах

201: Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад боловсруулах: барааг боловсруулах, эсхүл баяжуулах

202: Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад боловсруулах: тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх

203: Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад боловсруулах: засвар хийх

⁴ БТКУС-ын 51 кодонд хонины угаасан ноос, самнасан ноос, угаасан, самнасан ноолуур, ноос ноолууран утас ээрмэл, даавуу зэрэг ангилагддаг.

442: Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах: тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн

502: Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулж буцаан гаргах нөхцлөөр түр оруулах: тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх

621: Хилийн чанадад боловсруулахаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах: тухайн барааг боловсруулах, эхсүл баяжуулахаар гаргасан

623: Хилийн чанадад боловсруулахаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах: тухайн бараанд засвар хийхээр гаргасан.


Самнасан ноос ноолуурын 90 орчим хувь нь түүхий эдийн байдлаар экспортод гардаг бөгөөд нийт экспортын 30,4 хувь нь боловсруулалтын түр горимыг ашиглан хилийн чанадад боловсруулсан статистик байна (Хүснэгт4) Эндээс дүгнэхэд ноос ноолууран утас, ээрмэл, даавуу, нэхмэлийг боловсруулах технологийн үйлдвэрүүд шаардлагатай байгаа нь харагдаж байна. Ноос ноолуурын түүхий эд, мөн ээрмэл, утасны экспортын 80 орчим хувийг БНХАУ эзэлж байна.

Хүснэгт 3. Угаасан, самнасан ноос ноолуур 2025 /түүхий эд импортлогч орнууд,хувиар/



Ноос ноолууран бүтээгдэхүүний экспортын нэг гол зах зээл нь Европын холбоо, нийт экспортын 20% орчим эзлэдэг. 2025 онд **29254** мянган ам.долларын ноос ноолууран бүтээгдэхүүн экспортлосноос **22626** мянган ам.долларын бүтээгдэхүүн Европын холбооны улсууд руу хийгджээ. БНХАУ руу 991 мянган ам.долларын бүтээгдэхүүн экспортлогдсон байна.

Хүснэгт 4. Монголын ноос ноолууран бүтээгдэхүүнийг худалдан авагч орнууд 2025 /үнийн дүн, тоо хэмжээ, хувиар/



Дээрх хүснэгт 2-оос харахад дунджаар 380 сая орчим ам.долларын ноос, ноолуурын түүхий эд экспортлосон бол үйлдвэрлэгчид 10 орчим сая ам.долларын ноос, ноолууран ээрмэл утас, даавуу импортлон авчээ. Энэ нь боловсруулах үйлдвэрүүдийн инноваци, хүчин чадалтай холбоотой бөгөөд утас, ээрмэл, даавуу үйлдвэрлэх хүчин чадал, технологийг нэмэгдүүлж, сайжруулснаар импортыг бүрэн орлох боломжтой байна.

Салбарын эерэг өөрчлөлтүүд⁵

- 2025 оны хоёрдугаар сараас хойш угаасан ноолуур экспортлохыг хориглосон.
- Хэрэглэгчдийн худалдан авах зан төлөв нь экологид ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг илүүд үзэх болсон.
- Евразийн хэлэлцээр хэрэгжсэнээр ноос, ноолуурын 204 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэлэлцээрийн орнууд руу татваргүй экспортлох боломж бүрдэнэ.
- Европын холбооны GSP+ Ерөнхий хөнгөлөлтийн системийн хүрээнд Монгол Улсаас гаралтай 7,200 нэр төрлийн бүтээгдэхүүн тарифын хөнгөлөлтөд хамрагдаж байна.
- Монгол Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд ноос, ноолууран бүтээгдэхүүн хөнгөлөлтөд хамаарч байна.
- Европын зах зээл дэх ноолуурын эрэлт тогтмол байна.

⁵ “Монголын ноолуурын салбарын бизнесийн орчин ба хөрөнгө оруулалтын боломжийн өнөөгийн байдал” илтгэл, 8 дахь тал, МННХ, (2025)

- БНХАУ-д 100 сая ширхэг ноолууран бүтээгдэхүүн импортолсон нь өмнөд хөршийн зах зээлд томоохон боломж байгааг харуулж байна.
- АНУ-ын зах зээлд Монгол ноолуурыг сурталчлах үйл ажиллагааны үр дүнд тус улсын эрэлт, хэрэглээ тогтвортой өсөж байна.
- Ноос ноолууран даавуу үйлдвэрлэхэд малын тавлаг байдал, ноолуур бэлтгэл, шошгололт, үйлдвэрлэл, мөшгөлтийн тогтолцоонд тавигдах шаардлагыг тогтоосон Монгол Улсын санаачилсан ISO стандарт батлагдан зөвшөөрөгдсөн.

Хөрөнгө оруулалт

Ноос ноолуурын салбарын боловсруулалт, үйлдвэрлэлийн статистик мэдээллүүдээс харахад ноос ноолуурыг гүн боловсруулах буюу сайн чанарын өндөр зэрэглэлийн ноолууран утас, даавуу үйлдвэрлэх, байгаль орчинд ээлтэй, шинэ техник технологи инновацийг шингээсэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах чиглэлээр хөрөнгө оруулалт татах, одоо байгаа үйлдвэрүүдийг өргөтгөх, шинэ технологи нэвтрүүлэх замаар хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах боломжууд байгаа нь харагдаж байна. Цаашлаад монгол ямааны нарийн микрон, байгалийн өнгө, газар зүйн тэмдэгээр баталгаажсан давуу талуудаа ашиглан гадаад зах зээлд борлуулах зэрэг боломжууд байх боломжтой.

Дэд бүтэц, ханган нийлүүлэлт

Ноос ноолуурын салбар ялангуяа боловсруулах, үйлдвэрлэх салбар нь нэмүү өртгийг хамгийн ихээр шингээн ажлын байр, зах зээлд өрсөлдөхүйц цалинг бий болгох, үүнийг дагаад ур чадварын нөөцийг бий болгодог салбар тул төрөөс түүхий эдийн үнийг тогтвортой байлгах, түүхий эдийн гарцыг тогтмол буюу нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингээх зорилгоор үе шаттай бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ирсэн. Энэ дэмжлэгийн тусламжаар ноос, ноолуурын салбар харьцангуй бие дааж байгаа боловсруулах салбарт тооцогдож байна. Харин манай орны газарзүйн байршил, тээвэр логистикийн хязгаарлагдмал байдал, тээврийн зардал зэргээс хамаарч дэлхийн зах зээлд жигд гарах боломжийг хякгаарлаж байна. Иймд салбарын бодлого дэмжлэгт тээвэр логистикийн асуудал хамтад нь харж үзэх нь зүйтэй байна. Энэ салбарт бодлогыг хэрэгжилтийг дэмжин мэргэжлийн холбоод ч үйл ажиллагаагаа уялдуулан явуулж байна.

Монголын ноос ноолуурын салбарын кластерийн зураглал

Малчид → Хоршоод → Анхан боловсруулах үйлдвэрүүд (угаах, самнах) → Ээрэх /Нэхэх/

Сүлжих → Бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид → Экспортлогчид → Гадаадын брэндүүд

Ноос ноолуурын кластерийн оролцогчид:

Түүхий эд нийлүүлэгчид/малчид: 2023 онд 80 орчим малчны хоршоо, тэдгээрээс 49 хоршоо SFA баталгаажсан түүхий ноолуур нийлүүлсэн. Тэд жил бүр 1300+ тонн SFA Certified түүхий эдийг дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлдэг.⁶

Анхан шатны болон гүн боловсруулах үйлдвэрүүд: 173 ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд байна гэсэн мэдээ байна.

Сүлжмэл, нэхмэл, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид: Нэхэх, сүлжих чиглэлийн 14 цогцолбор, 80 гаруй жижиг дунд үйлдвэр ажилладаг.⁷

Тогтвортой ноолуурын систем UNDP-ийн “Sustainable Cashmere Platform” Олон талт оролцогчдын үндэсний түвшний хамтын ажиллагааны механизм

Экспорт, худалдааны сувгууд: Европын холбоо, Итали, Англи, Япон зэрэг орнууд руу самнасан, угаасан ноолуур, бэлэн бүтээгдэхүүн экспортолдог⁸. Экспортлогч нарын талаарх албан ёсны статистик мэдээлэл хангалтгүй байна.

Монголын Ноос Ноолуурын Холбооноос олгодог чанарын гэрчилгээнүүд⁹:

QUALITY, STANDARD CERTIFICATION

CERTIFICATE OF CONFIRMITY
If the standard meets with Mongolian MNS standard

EXPORT CERTIFICATE
Washed wool and dehaired cashmere products specified in Article 13.3 of the Law on Standardization, Technical Regulation, Conformity Assessment and Accreditation are subject to mandatory certification by Government Order No. 291...

MONGOLIAN NOBLE FIBRE PRODUCT QUALITY STANDARD
Product quality indicator
• Dyeing stability
• Size sustainability
• Cashmere content
• Mongolian origin raw material

SUSTAINABLE TEXTILE PRODUCTION SYSTEM STANDARD
• Appropriate use of natural resources
• Social responsibility
• Production waste
• Harmless to human and nature
• Energy and chemical usage
• Labor protection and animal rights

PROTECTED GEOGRAPHICAL INDICATION (GI)
"Geographical indication" means the geographical name of a country, region or place where goods or products are produced, which have a quality, reputation or other distinctive characteristics determined by factors such as the natural and climatic conditions of the area or the customs of the people of that area.
➢ White
➢ Beige
➢ Light grey
➢ Brown
➢ Dark

Эрсдэл, улирлын болон байгалийн нөлөөлөл:

- Бэлчээрийн доройтлоос шалтгаалан өвөл, хаврын саруудын үргэлжлэх хугацаа уртассан, хаврын улирал нь илүү хахир хатуу, урт үргэлжилдэг болсон;
- Цаг агаарын энэхүү өөрчлөлтийн улмаас ямааны ноолуурын макроны хэмжээ томрох, ноос ноолуур самнах хугацааг хойшлуулж байгаа нь экспортын гарцанд нөлөөлж байна;

⁶ <https://sustainablefibre.mn/storage/2025/06/2023-SFA-Mongolia-Overview.pdf>

⁷ <https://www.mongoltextile.mn/mn/>

⁸ <https://www.mongolbank.mn/file/1406d6884e256e3eedfbb7a905898ad1/files/Presentation%203.pdf>

⁹ “Монголын ноолуурын салбарын бизнесийн орчин ба хөрөнгө оруулалтын боломжийн өнөөгийн байдал” илтгэл, 3 дахь тал, МННХ, (2025)

- Цаг агаарын нөхцөл байдлаас (ган, зуд) хамаарсан малын хорогдол нь түүхий эдийн үнэд савалгаа үүсгэх, түүхий эдийн бэлтгэл тасалдах;
- Европын холбоо руу экспортод гаргах бүтээгдэхүүнд тавигддаг шалгуур, стандартууд өндөрсөн. Сертификатуудыг авах зардал өндөр;
- Инфляцийн өсөлт, ОХУ Украйны дайны нөхцөл байдлаас хамаарч тээвэр логистикийн үнэ нэмэгдэж, хугацаа уртассан нь европын хэрэглэгчдийн ноолуур худалдан авалт багасахад нөлөөлсөн;
- Ноос ноолуур цуглуулахаас экспортлох хүртэлх явцад төрийн болон мэргэжлийн холбоодын чанар баталгаажуулалт, гэрчилгээ, хяналт шалгалтад хамруулах, бичиг баримт бүрдүүлэх үйл явцын талаарх мэдээлэл тодорхойгүй, зарим талаар давхцаж байгаа нь хүндрэл үүсгэж байна. (шинжилгээ, хөдөө аж ахуйн биржийн бичиг, гарал үүслийн бичиг, гэрчилгээ, чанарын баталгаажуулалт, стандартууд г.м);

ДҮГНЭЛТ

Ноос ноолуурын салбар нь уул уурхайн бус экспортын 6-7 хувийг бүрдүүлдэг, дэлхийн ноос ноолуурын түүхий эдийн 45 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг, нөөц боломж ихтэй салбар юм. Энэ салбарыг хөгжүүлэх, экспортод эзлэх, дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтөд эзлэх хувийг нэмэгдүүлэх, салбарын хөгжлийг дэмжсэнээр малчнаас эхлүүлээд нийт эдийн засагт нэмүү өртөг шингээдэг салбарт тул төрөөс урт богино, дунд хугацааны бодлогын болон санхүүгийн дэмжлэг, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн.

Үүний ачаар уг салбар уул уурхайн бус экспорт, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт харьцангуй бие даасан салбар болсон байна. Цаашид энэ салбарыг хөгжүүлэхэд түүхий эдээс илүү нэмүү өртөг шингэсэн боловсруулалтын үе шатуудад анхаарч, дутагдаж байгаа инноваци, технологийг оруулж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих, худалдааны хөнгөлөлтийн хэлэлцээр, эдийн засгийн эдийн засгийн хэлэлцээрүүдийг үр ашигтай ашиглан эксдортлох худалдааны чиглэл боловсруулж хэрэгжүүлэх, ноос ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн боломжит зах зээлууд рүү судалгааны үндсэн дээр гаргах ажлыг шат дараатайгаар хийх, тээвэр логистикийн асуудлыг худалдааны бодлого, эдийн засгийн хэлэлцээрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлага байгаа нь энэхүү бичил судалгааны явцад гарч байна.

2025 оны самнасан ноолуурын экспорт: 4,000 тонн

Экспортын орлого: 330.6 сая ам.доллар

2024 онтой харьцуулахад: +28.7% өсөлт